

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/56/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Долгоржав Утас: 263533 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эйч Эл Би Монголиа Аудит ХХК Захирал: Ч.Энхтуяа Цахим хаяг: enkhtuya@hlb.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.5.3 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	13
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Албан шаардлага	17
5.2 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН УЛААНБААТАР ХОТЫН
НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ
НЭГЖИЙН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Б.БААТАРЗОРИГ ТАНАА

2026.04.03 № 06/843
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төслийн үйл ажиллагааны 2025 оны урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийслэлийн төсвөөс 534,420.4 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 476,697.5 мянган төгрөг буюу 89.2 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 18,524.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 18,163.2 мянган төгрөгөөр, тэтгэврийн даатгалын зардлыг 21,034.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Нийслэлийн төсвөөс олгосон санхүүжилтийн гүйцэтгэлийг Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын санхүүгийн тайланд тайлагнадаг байна.

Аудитын гол асуудал

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2025 онд Толгойт дэд төвийн холбооны шугам сүлжээ, ариутгах татуургын шугам суурилуулалт, авто зам, инженерийн шугам сүлжээний I үе шат, авто зам, инженерийн шугам сүлжээний II үе шат, хуваарилах байгууламжууд, 10 кв-ын цахилгаан дамжуулах кабель шугамын ажил, Дамбадаржаа дэд төвийн 83 дугаар шугам ус түгээх байрны

тохижилт гэсэн 6 барилга угсралтын ажлын 60,235,402.3 мянган төгрөг, Толгойт дэд төв дэх сургалтын төвийн тоног төхөөрөмж худалдан авах ажлын 340,000.0 мянган төгрөгийн гэрээг тус тус байгуулан, нийт Төрийн сангийн харилцах дансаар 23,670,678.8 мянган төгрөг, Азийн хөгжлийн банкны шууд төлөлтөөр 35,227,677.2 мянган төгрөгийг гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн байна.

Төслийн хүрээнд тайлант онд ашиглалтад орж улсын комиссын актаар 83,395,041.4 мянган төгрөгийн барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид шилжүүлж бүртгэлээс хассан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсөл хөтөлбөрийг гурван үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд 73.2 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банкны ажлын хэсэг төслийн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан бөгөөд төслийн тулгамдаж байгаа асуудлуудыг холбогдох талуудтай хэлэлцэн Азийн хөгжлийн банкнаас төслийг санхүүжүүлэх хугацааг 2026 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хүртэл, Европын хөрөнгө оруулалтын банкнаас төслийг санхүүжүүлэх хугацааг 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хүртэл тус тус сунгасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	483,982,440,001.18	510,001,556,349.81
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	33,073,094,778.63	44,305,297,881.08
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	33,073,094,778.63	44,305,297,881.08
31210	Төгрөг	494,783,321.17	208,833,500.90
31212	Төрийн сангийн харилцах	494,783,321.17	208,833,500.90
31220	Гадаад валют	32,578,311,457.46	44,096,464,380.18
31221	Төрийн сангийн харилцах	32,554,972,218.70	44,096,464,380.18
31223	Арилжааны банк дахь харилцах	23,339,238.76	-
33	АВЛАГА	29,999,344.21	42,524,284.60
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	22,062.08	-
33500	БУСАД АВЛАГА	29,977,282.13	42,524,284.60
33510	Байгууллагаас авах авлага	29,977,282.13	42,524,284.60
34	УРЬДЧИЛГАА	16,477,259,196.07	8,204,378,360.32
34600	Урьдчилж гарсан зардал	16,477,259,196.07	8,204,378,360.32
35	БАРАА МАТЕРИАЛ	10,820,422.87	19,290,113.00
35470	Бусад хангамжийн материал	10,820,422.87	19,290,113.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	434,391,266,259.40	457,430,065,710.81
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	428,304,268,129.72	447,678,808,489.83
26810	Бусад эргэлтийн хөрөнгө барьцаа	6,086,998,129.68	9,751,257,220.98
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	34,157,580.63	59,173,565.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	34,157,580.63	59,173,565.14
39200	Биет хөрөнгө	34,157,580.63	59,173,565.14
39203	Тээврийн хэрэгсэл	113,950,000.00	113,950,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(108,252,499.80)	(113,950,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	109,569,818.00	114,520,372.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(91,502,886.24)	(63,542,889.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,111,956.48	31,096,014.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	(69,718,807.81)	(22,899,932.21)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	484,016,597,581.81	510,060,729,914.95
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	38,773,276,885.44	55,643,168,660.04
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	38,773,276,885.44	55,643,168,660.04
41310	Ажиллагсадтай холбоотой өглөг	146,944.71	186,698.11
41361	Байгууллагад төлөх өглөг	750,375,191.66	6,394,968,603.66
4136101	Барьцаа хөрөнгийн өглөг	6,257,128,135.76	8,868,387,606.72
41363	Татвар, НДШ-ийн өглөг	34,257.90	40,445.44
414	Урьдчилж орсон орлого	31,765,592,355.41	40,379,585,306.11
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	445,243,320,696.37	454,417,561,254.91
51	Засгийн газрын хувь оролцоо	445,243,320,696.37	454,417,561,254.91
51200	Хуримтлагдсан үр дүн	445,243,320,696.37	454,417,561,254.91
51210	Өмнөх үеийн үр дүн	423,189,583,207.89	445,210,431,155.79
51220	Тайлант үеийн үр дүн	22,020,847,947.90	9,292,593,890.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	32,889,540.58	(85,463,791.72)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	484,016,597,581.81	510,060,729,914.95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	104,794,959,481.89	90,898,973,099.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	98,727,697,462.89	90,898,973,099.02
120	Нийтлэг татварын бус орлого	98,727,697,462.89	90,898,973,099.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	98,727,697,462.89	90,898,973,099.02
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	92,606,629,646.11	60,728,728,023.09
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,114,767,816.78	30,163,505,075.93
120009	Бусад орлого	6,300,000.00	6,740,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,067,262,019.00	-
1330	Төсвийн захирагчдаас	6,067,262,019.00	-
1320050	Хөрөнгийн санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага	6,067,262,019.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	82,850,760,961.26	84,670,761,293.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,850,760,961.26	84,670,761,293.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,850,760,961.26	84,670,761,293.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,345,578,695.90	1,249,643,611.58
210105	Гэрээт ажлын хөлс	1,345,578,695.90	1,249,643,611.58
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	170,857.75	90,017.35
2108080	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	170,857.75	90,017.35
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,505,011,407.61	83,421,027,664.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,479,121,083.55	83,394,952,811.13
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,890,324.06	26,074,853.74
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	21,944,198,520.63	6,228,211,805.22
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	158,899,930.43	3,372,123,215.47
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	158,899,930.43	3,372,123,215.47
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	82,250,503.15	307,741,129.85
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	19,138,435.45
225104	Хүүгийн орлогын зардал	-	219,091,276.34
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	82,250,503.15	69,511,418.06
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	76,649,427.28	3,064,382,085.62
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	22,020,847,947.90	9,292,593,890.84

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	49,393,877,284.35	32,636,210,878.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,393,877,284.35	32,636,210,878.34
120	Нийтлэг татварын бус орлого	49,393,877,284.35	32,636,210,878.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,393,577,284.35	32,636,210,878.34
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	49,387,577,284.35	32,629,470,878.34
120009	Бусад орлого	6,300,000.00	6,740,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮГИЙН ОРЛОГО	-	-
1330	Төсвийн захирагчдаас	-	-
133003	Хөрөнгийн	-	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,950,772.39	1,071,025,615.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,950,772.39	1,071,025,615.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,950,772.39	1,071,025,615.07
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	170,857.75	846,684,338.73
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	170,857.75	90,017.35
210818	Бусад мөнгөн зарлага	-	846,594,321.38
2109	Бараа үйлчилгээний бусад зарлага	25,779,914.64	5,250,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,779,914.64	5,250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	219,091,276.34
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	219,091,276.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		219,091,276.34
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	49,367,926,511.96	31,565,185,263.27
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	39,358,528,823.66	23,670,678,852.77
	Гадаад эх үүсвэрээр	39,358,528,823.66	23,670,678,852.77
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	39,358,528,823.66	23,670,678,852.77
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	41,597,872.08	393.97
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	26,671,548.31	3,337,697,069.91
VIII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(14,926,323.77)	3,337,696,675.94
IX	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	9,994,471,364.53	11,232,203,086.43
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	23,078,623,414.10	33,073,094,778.63
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,073,094,778.63	44,305,297,881.08

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	17,540,000.00	423,188,440,350.98	423,205,980,350.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн залруулга	-	-	1,142,856.91	1,142,856.91
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	17,540,000.00	423,189,583,207.89	423,207,123,207.89
Дахин үнэлгээний зөрүү	-	15,349,540.58	-	15,349,540.58
Тайлант үеийн үр дүн	-	-	22,020,847,947.90	22,020,847,947.90
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	32,889,540.58	445,210,431,155.79	445,243,320,696.37
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Дахин үнэлгээний зөрүү	-	(118,353,332.30)	-	(118,353,332.30)
Тайлант үеийн үр дүн	-	-	9,292,593,890.84	9,292,593,890.84
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	(85,463,791.72)	454,503,025,046.63	454,417,561,254.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,319,897,000.00	59,009,042,589.33	310,854,410.67	99.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	59,319,897,000.00	59,009,042,589.33	310,854,410.67	99.5
ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	59,319,897,000.00	59,009,042,589.33	310,854,410.67	99.5
Гадаад төслийн зээлээс санхүүжих зээл	59,319,897,000.00	59,009,042,589.33	310,854,410.67	99.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,319,897,000.00	59,009,042,589.33	310,854,410.67	99.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	59,319,897,000.00	59,009,042,589.33	310,854,410.67	99.5
Гадаад эх үүсвэрээс санхүүжих	59,319,897,000.00	59,009,042,589.33	310,854,410.67	99.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	33,073,094,778.63	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	44,305,297,881.08	-	-
Төсвийн тохируулга	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	26	23	3	88.5
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	25	22	3	88.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл” нь 3 үе шаттай хэрэгжих ба төслийн санхүүжүүлэгч байгууллага нь Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар юм.

Үе шат 1: Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийг инженерийн дэд бүтцээр хангаж, хотын дэд төв болгон хөгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх,

Үе шат 2: Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвүүдэд хотын дэд бүтцийг шинэчлэх өргөтгөх, Баянхошуу, Сэлбэ дэд төвд нэмэлт хөрөнгө оруулалт хийх, нийгэм эдийн засгийн барилга байгууламжийг барих,

Үе шат 3: Шархад, Толгойт дэд төвүүдийн дэд бүтцийг шинэчлэх, бусад дэд төвүүдтэй холбон, нийгэм эдийн засгийн барилга байгууламж барих зорилтыг тус тус тодорхойлсон.

Төслийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт нийт зардал 344,200.0 мянган ам.доллаароор батлагдсан бөгөөд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр 160,000.0 мянган ам.долларыг, Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар 3,700.0 мянган ам.долларыг, Европын хөрөнгө оруулалтын банкны хөнгөлөлттэй зээлээр 60,300.0 мянган ам.долларыг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүжилтээр 120,200.0 мянган ам.долларыг тус тус санхүүжүүлэхээр батлагдсан.

Хүснэгт 1. Санхүүжилтийн задаргаа

/мянган ам.доллаароор/

Эх үүсвэр	Хөтөлбөр	I үе шат	II үе шат	III үе шат
АХБ-ны санхүүжилт	163,700.0	53,700.0	66,350.0	43,650.0
(COL)	70,340.0	22,500.0	29,240.0	18,600.0
(OCR)	89,660.0	27,500.0	37,110.0	25,050.0
МОН-0380	37,000.0	3,700.0	-	-
НЗДТГ-ын төсөв	12,020.0	33,150.0	35,150.0	51,900.0
ЕХОБ-ны санхүүжилт	60,300.0	22,010.0	119,640.0	18,650.0
Нийт	344,200.0	108,860.0	121,140.0	114,200.0

Төсөл нь дараах үндсэн 4 үр дүнд хүрнэ. Үүнд:

1. Тэргүүлэх ач холбогдол бүхий дэд төвүүдэд авто зам болон хотын дэд бүтцийн үйлчилгээ өргөжиж, тэдгээрийн хоорондын холболт сайжирна;
2. Зорилтот хэсгүүд дэх эдийн засгийн болон төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ;
3. Дэд бүтцийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааны үр дүн сайжирна;
4. Хот байгуулалт, хөтөлбөрийн менежмент, үйлчилгээг хүргэх чиглэлээр институци болон чадавх бэхэжнэ.

Төсөл, хөтөлбөр нь дараах үйл ажиллагаануудаас хамаарна. Үүнд:

1. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт: Төслийн хүрээнд хийгдэх барилга угсралтын ажлуудын газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулан, АХБ-аар батлуулснаар тухайн батлагдсан төлөвлөгөөний дагуу газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
2. Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулж, батлуулах: Төсөл, арга хэмжээний нөлөөлөлд өртсөн нэгж талбаруудын газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг зохион байгуулж, төлөвлөсөн инженерийн болоод нийгмийн барилга байгууламжийн газрын гэрээ, гэрчилгээ гарснаар барилгын тухай хууль болон холбогдох дүрэм журмын дагуу тухайн баригдах барилга байгууламжийн ажлын

даалгавар, техникийн нөхцөлүүдийг холбогдох мэргэжлийн болон хангагч байгууллагуудаас авч, зураг төсөл, төсвийг эцэслэн боловсруулж, магадлалаар батлуулдаг. Тухайн төсөл, арга хэмжээний зураг төсөл батлагдсанаар төслийн худалдан авах ажиллагааг эхлүүлэх боломж бүрддэг.

3. Төслийн худалдан авах ажиллагаа: Төслийн баримт бичигт зааснаар төслийн хүрээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг Азийн хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны журмын дагуу Азийн хөгжлийн банкнаас баталсан төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу Азийн хөгжлийн банкны зохих хяналттайгаар зохион байгуулна.
4. Төслийн үйл ажиллагаа: Төслийн хүрээнд төлөвлөсөн аливаа барилга угсралтын ажлууд нь нарийвчилсан зураг төсөл боловсруулах, төслийн худалдан авах ажиллагаа, газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлт бүрэн дууссанаар хэрэгжиж эхлэх бөгөөд барилгын ажлыг зураг төсөл зохиогчийн хяналт, захиалагчийн техникийн хяналттайгаар гүйцэтгүүлж, ашиглагч байгууллага бөгөөд төслийн үр шимийг хүртэгчид хүлээлгэн өгнө.

Монгол Улсын сангийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 69 дугаар тушаалаар Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц орон тоог шинэчлэн нийт 26 ажилтантай баталсан бөгөөд 2025 онд 23 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг мөрдөж ажилладаг.

Журмын 1.2-т “Журмыг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Барилгын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг байна.

Тайлант хугацаанд төслийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсон;
- “Төсвийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсон;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсон;
- “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд”-д нэмэлт өөрчлөлт орсон;
- “Шилэн дансны тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсон;
- Сангийн сайдын 2025 оны 1 сарын 03-ний өдрийн А/3 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ын журам”.

Төслийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-т заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,044,132.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	33,073,094.8	44,305,297.9	11,232,203.1
Авлага	29,999.3	42,524.3	12,524.9
Урьдчилгаа	16,477,259.2	8,204,378.4	(8,272,880.8)
Бараа материал	10,820.4	19,290.1	8,469.7
Бусад эргэлтийн хөрөнгө	434,391,266.3	457,430,065.7	23,038,799.5
Үндсэн хөрөнгө	34,157.6	59,173.5	25,015.9
Нийт хөрөнгө	484,016,597.6	510,060,729.9	26,044,132.3
Өр төлбөр	38,773,276.9	55,643,168.7	16,869,891.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	445,243,320.7	454,417,561.2	9,174,240.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	484,016,597.6	510,060,729.9	26,044,132.3

Дээрх хүснэгтээс үзэхэд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, урьдчилж орсон орлого, засгийн газрын хувь оролцооны данстууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 44,305,297.9 мянган төгрөгт хүрч, 11,232,203.1 мянган төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банкны зээлийн эх үүсвэрээс 8.01 сая евро буюу 32,629,470.8 мянган төгрөг, тендерийн баримт бичиг худалдсаны орлогоор 6,740.0 мянган төгрөг, валютын ханшийн зөрүүний олз 3,337,697.1 мянган төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлж, урсгал зардалд 1,071,025.6 мянган төгрөгийг, хөрөнгө оруулалтын зардалд 23,670,679.2 мянган төгрөгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Мөн Төслийн үе шат 1-ийн МОН-3099 COL эх үүсвэрийг хаасантай холбоотой ашиглагдаагүй зээлийн үлдэгдэл болох 737,774.75 мянган төгрөг, төслийн үе шат 2-ын МОН-3526 COL эх үүсвэрийн 2019-2022 онуудын цалинтай холбоотой гарсан зээлийн тооцоог Азийн хөгжлийн банкттай тооцоо нийлж, ашиглагдаагүй зээл болох 108,819.57 мянган төгрөгийг тус тус Азийн хөгжлийн банк руу буцаасан.

Авлага дансны үлдэгдэл 42,524.3 мянган төгрөг болж, 12,524.9 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлттэй холбоотой байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 8,204,378.4 мянган төгрөг болж 8,272,880.8 мянган төгрөгөөр буурсан Chine Second Metallurgy Group компанид олгосон дулааны станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн төлбөрийг суутгуулснаар дансны үлдэгдэл буурсан байна.

Бараа материал дансанд Петростар ХХК-ийн түлшний картын үлдэгдэлд 19,290.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бусад эргэлтийн хөрөнгө 457,430,065.7 мянган төгрөг болж 23,038,799.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төслийн үйл ажиллагааны үр дүнгээр 109,008,622.0 мянган төгрөгөөр хөрөнгө нэмж бүртгэсэн, 85,969,822.6 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлсэн. Бусад эргэлтийн хөрөнгө нь төслийн үр дүнд бий болж байгаа дэд бүтэц болон барилга байгууламж, тоног төхөөрөмжийн дүнг илэрхийлнэ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 59,173.6 мянган төгрөг болж 25,016.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Чадавхыг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан Т.02-CS02 дугаар гэрээний хугацаа 2024 оны 12 дугаар сард дуусгавар болсон ба ашиглагдаж байсан хөрөнгийг 188,582.6 мянган төгрөгийн 236 ширхэг эд хөрөнгийг анх худалдан авсан үнээр нь шилжүүлэн ирснийг дахин үнэлгээ хийж 118,353.3 мянган төгрөгөөр хорогдуулан бүртгэж орлого авсан. Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2025 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн А/175 дугаар тушаалаар 114,294.7 мянган төгрөгийн өртөгтэй 95,156.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг акталж бүртгэлээс хассан. Мөн тайлант онд 26,074.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал бүртгэсэн нь тус тус нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 55,643,168.7 мянган төгрөг болж, 16,869,891.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн төслийн үр дүнд бий болж байгаа дэд бүтэц, барилга байгууламж болон нийлүүлж байгаа бараа ажил үйлчилгээний гэрээний дүнгээс тооцсон баталгаа болон ажлын гүйцэтгэлийн төлөөгүй өглөгүүд голлон нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 454,417,561.2 мянган төгрөгт хүрч 9,174,240.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын эх үүсвэрээс 112,047,501.0 мянган төгрөгөөр, Нийслэлийн төсвөөс 30,477,948.1 мянган төгрөгөөр, нийт 142,525,449.1 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Гадаадын эх үүсвэрийг 53,211,194.9 мянган төгрөгөөр бууруулж, 59,319,897.0 мянган төгрөгөөр, Нийслэлийн төсвөөс авах эх үүсвэрийг 30,477,948.1 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Нийслэлийн төсвийн гүйцэтгэл нь Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын тайланд нэгтгэгддэг тул нийслэлийн төсвийн гүйцэтгэлийг уг тайланд оруулаагүй бөгөөд зөвхөн гадаад эх үүсвэрийн төлөвлөгөө гүйцэтгэлийг оруулсан болно.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төслөөс хэрэгжүүлж 4 үр дүнгийн зардлыг санхүүжүүлэхээр Нийслэлийн төсвөөс 24,907,948.1 мянган төгрөг, гадаадын эх үүсвэрээс 58,836,306.1 мянган төгрөг, нийт 83,744,254.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Төсвийн нийт зардал 59,009,042.6 мянган төгрөг буюу 99.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, зориулалтын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт (%)
70207	Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр	59,319,897.0	59,009,042.6	310,854.4	99.5
1320050	Нийслэлийн төсвөөс	30,477,948.1	24,907,948.1	5,570,000.0	81.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл, хөтөлбөр нь 3 үе шаттайгаар дэд төвүүдэд бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэж байгаа бөгөөд хэрэгжилтийн явц 73.2 хувьтай байна.

Хүснэгт 4. Төсөл арга хэмжээний хэрэгжилтийн хувь

Үйл ажиллагаа	Бодит явц(%)
ТУН байгуулах	100.0
1 дүгээр үе шатны үйл ажиллагаа	100.0
2 дугаар үе шатны үйл ажиллагаа	70.2
3 дугаар үе шатны үйл ажиллагаа	47.8
Төслийн хаалт	0.0
Хөтөлбөр	73.2

Төслийн 1 дүгээр үе шатны хүрээнд:

Баянхошуу, Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээс 53,700.0 мянган ам.доллар, Европын хөрөнгө оруулалтын банкны хөнгөлөлтэй зээлээс 22,010.0 мянган ам.доллар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүжилтээс 33,150.0 мянган ам.доллар, нийт 108,860.0 ам.долларын санхүүжилттэйгээр 2014 оны 09 дүгээр сарын 30-аас 2021 оны 12 дугаар сарын 31-ний хооронд бүрэн хийгдэж дууссан байна.

Төслийн 2 дугаар үе шатны хүрээнд:

Дамбадаржаа, Дэнжийн мянга төвүүдийн бүтээн байгуулалтыг хийх бөгөөд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд зайлшгүй шаардлагатай нэмэлт бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэж байна. Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлт 99.7 хувь, зураг төсөл боловсруулах, батлуулах 91.1 хувь, Худалдан авах ажиллагаа 76.3 хувь, Барилга угсралт 56.0 хувь, зөвлөх үйлчилгээ 71.8 хувь байна. Энэ үе шатны хэрэгжилтийн явц нийт 70.2 хувьтай байна.

Хүснэгт 5. II дугаар үе шатны хэрэгжилтийн хувь

Үйл ажиллагаа	Бодит явц(%)
Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлт	99.7
Төлөвлөлт	100.0
Хэрэгжүүлэлт	99.6
Зураг төсөл боловсруулах, батлуулах	91.1
Худалдан авах ажиллагаа	76.3
Барилгын ажил	74.3
Зөвлөх үйлчилгээ	95.8
Бараа	85.4
Барилга угсралт	56.0
Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	56.2
Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд	55.1
Зөвлөх үйлчилгээ	71.8
Нийт	70.2

Төслийн 3 дугаар үе шатны хүрээнд:

Толгойт, Шархад дэд төвүүдийн бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэж байна. Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлт 97.1 хувь, зураг төсөл боловсруулах, батлуулах 78.7 хувь, Худалдан авах ажиллагаа 50.6 хувь, Барилга угсралт 24.8 хувь, зөвлөх үйлчилгээ 76.4 хувь байна. Энэ үе шатны хэрэгжилтийн явц нийт 47.8 хувьтай байна.

Хүснэгт 6. III дугаар үе шатны хэрэгжилтийн хувь

Үйл ажиллагаа	Бодит явц (%)
Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлт	97.1
Төлөвлөлт	100.0
Хэрэгжүүлэлт	97.1
Зураг төсөл боловсруулах, батлуулах	78.7
Худалдан авах ажиллагаа	50.6
Барилгын ажил	51.5
Зөвлөх үйлчилгээ	86.0
Бараа	3.0
Барилга угсралт	24.8
Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	21.5
Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд	32.3
Зөвлөх үйлчилгээ	76.4
Нийт	47.8

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

1. Монгол Улсын сангийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 69 дугаар тушаалаар Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн бүтэц орон тоог шинэчлэн нийт 26 ажилтантай баталсан бөгөөд 2025 онд 88.5 хувь буюу 23 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулсан байна.

2. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, унаа хоолны хөнгөлөлт, гадаад томилолт, гадаад арга хэмжээ, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлыг санхүүжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төслийн удирдах хорооны 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01 дугаар дугаар тогтоолоор 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 12,521.6 мянган ам.доллараар баталсан.

Төлөвлөгөөгөөр хөтөлбөрийн 2 дугаар үе шатанд 1 барилгын ажил, 2 зөвлөх үйлчилгээ, 2 бараа, 3 дугаар үе шатанд 4 барилгын ажил 4 барааг тус тус худалдан авахаар төлөвлөж, нийт 7 гэрээг байгуулж, 60,890,901.3 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Төслийн нийт Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 4 сард шинэчлэгдэн АХБ-аар батлуулсан бөгөөд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 14 дахь хувилбарт 34 барилгын ажил, 9 бараа, 6 зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөснөөс 2025 оны байдлаар 23 барилгын ажил, 44 бараа, 5 зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулаад байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд тус төсөл хэрэгжүүлэх нэгж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Эйч Эл Би Монголиа Аудит ХХК-ийн ахлах аудитор А.Билгүүн, Д.Пүрэвсүрэн, аудитор Ө.Батчимэг, П.Ганчимэг, туслах аудитор Г.Уранзул нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Р.Энх-Амгалан, захирал Ч.Энхтуяа нар анхан шатны хяналтыг, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Долгоржав, аудитын менежер В.Эрдэнэцогт, захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газар 2026 оны 1 дүгээр сарын 23-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр хүргүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 84,978,502.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 849,785.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл нь 2025 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус төсөл Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр байршуулах 16,432,494.45 мянган төгрөгийн 28 мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; 6-р зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр,

гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 16,309,578.3 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 7. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	16,309,578.3	4	16,309,578.3	4	0.0	100.0
Нийт дүн	4	16,309,578.3	4	16,309,578.3	4	0.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр нь 2026 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хэрэгжиж дуусах тул төслийн хүрээнд хэрэгжүүлж буй гэрээт ажлуудыг дүгнэх, зээлийн санхүүжилтээр хийгдэж буй бүтээн байгуулалтуудыг эрх бүхий байгууллагын шийдвэрээр ашиглагч байгууллагад шилжүүлсэн эсэх, төслийн дуусгаврын талаарх үр дүн, өр төлбөр болон авлагын үлдэгдлүүд бүрэн төлөгдөж хаагдсаныг дараагийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 383,674.5 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Долларын дансны үлдэгдлийн еврогийн ханшаар тэгшитгэж мөнгөн хөрөнгө дансны үлдэгдлийг 381,994.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 06 дугаар сарын 30-ний өдрийн А/175 дугаартай эргэлтийн бус хөрөнгө данснаас хасах тухай тушаалаас машин тоног төхөөрөмж данснаас 498.0 мянган төгрөгийн, тавилга эд хогшил данснаас 1,088.9 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус илүү хасаж журналд бүртгэсэн;
- Тавилга эд хогшил дансны элэгдлийн зардлыг 93.3 мянган төгрөгөөр илүү тооцоолж тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС-1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг” гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 632,331.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд, 591,319.6 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 41,012.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 632,331.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 849,785.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Бусад эргэлтийн хөрөнгийн данснаас 3 нэр төрлийн 88 ширхэг 591,319.6 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох дээд шатны байгууллагын тушаал шийдвэргүйгээр бүртгэлээс хасаж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;*”, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “*Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам*”-ын 5.1-т “*Хуулийн этгээдийн дарга /захирал/ нь илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг бусад байгууллага руу балансаас балансад шилжүүлэн өгөх болон бусад байгууллагын эзэмшилд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа энэ журмын 1.3-д заасан бичиг баримтыг бүрдүүлэн Өмчийн харилцааны газарт ирүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулан баланс тайланд хөдлөл өөрчлөлт хийнэ*”, 5.2-т “*Нийслэлийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн гарсан Нийслэлийн Засаг даргын захирамжаар, тээврийн хэрэгслийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар, бусад хөрөнгийг Өмчийн харилцааны газрын үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын шийдвэрийг үндэслэн гарсан Өмчийн харилцааны газрын даргын тушаалаар балансаас балансад шилжүүлнэ*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тусламжаар бэлтгэсэн хөрөнгийг тушаал шийдвэргүйгээр шилжүүлсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

2. Энигма констракшн ХХК-тай Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хороонд Гал түймэр унтраах, аврах 29 дүгээр ангийн барилга угсралтын 7,934,410.3 мянган төгрөгийн ажлыг 15 сарын хугацаанд гүйцэтгүүлэхээр 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр FSBKH дугаартай гэрээг байгуулсан байна. Гэрээт ажлын хугацааг 2 удаа сунгасан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэрээний хугацаа дууссан боловч барилга угсралтын ажлын гүйцэтгэл 60.2 хувьтай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.*”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*”, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.3-т “*Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана*”, Энигма констрашн ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 03-ний өдрийн FSBKH-Нэмэлт өөрчлөлт-2 дугаар бүхий Гэрээний ерөнхий нөхцөл болон заалтууд дахь нэмэлт өөрчлөлтийн 23.1, 37.1-д ажил дуусгах хугацааг “*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор*” гэж заасныг тус тус мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: FSBKH дугаартай гэрээ болон нэмэлт өөрчлөлтүүдийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийн дагуу гэрээний үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээний хугацааг мөрдөөгүй, төслийн зээлийн үр дүнг тооцоогүй, зөрчлийг арилгах албан шаардлаа хүргүүлэх

3. Модернхас ХХК болон Энерготех сервис ХХК-ийн түншлэлтэйгээр Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 20 дугаар хороо, Цэргийн хотхон орон сууцны хороолол орчмын Б хэсэгчилсэн талбай дахь гадна дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээний барилга угсралтын 4,734,941.5 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэхээр 12 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр SHTSC-A дугаартай гэрээг байгуулсан. Гэрээт ажлын хугацааг 1 удаа сунгасан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэрээний хугацаа дууссан боловч барилга угсралтын ажлын гүйцэтгэл 68.1 хувьтай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.*”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*”, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.3-т “*Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана*”, Модернхас ХХК, Энерготех сервис ХХК-уудын түншлэлтэй 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн SHTSC-A-Нэмэлт өөрчлөлт-1 дугаар бүхий Гэрээний ерөнхий нөхцөл болон заалтууд дахь нэмэлт өөрчлөлт 23.1, 37.1-д ажил дуусгах хугацааг “*2025 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн дотор*” гэсэн заалтыг тус тус мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: SHTSC-А дугаартай гэрээ болон нэмэлт өөрчлөлтүүдийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийн дагуу гэрээний үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээний хугацааг мөрдөөгүй, төслийн зээлийн үр дүнг тооцоогүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлаа хүргүүлэх

5.2 Зөвлөмж

1. Мөнгөн гүйлгээний зардлын нийт 45,771,472.2 мянган төгрөгийн гүйлгээг цахим төлбөрийн баримтын системтэй тулган шалгахад 41,012.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг гүйцэтгэгч байгууллага и-баримтын цахим системд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил үйлчилгээний төлбөрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулахад тавих дотоод хяналтыг сайжруулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Долларын дансны үлдэгдлийн еврогийн ханшаар тэгшитгэж мөнгөн хөрөнгө дансны үлдэгдлийг 381,994.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	381,994.3	-	-	1	381,994.3	1	381,994.3	-	-	-	-
2	Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 06 дугаар сарын 30-ний өдрийн А/175 дугаартай эргэлтийн бус хөрөнгө данснаас хасах тухай тушаалаас машин тоног төхөөрөмж данснаас 498,0 мянган төгрөгийн, тавилга эд хогшил данснаас 1,088.9 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус илүү хасаж журналд бүртгэсэн байна.	1	1,586.9	-	-	1	1,586.9	1	1,586.9	-	-	-	-
3	Тавилга эд хогшил дансны элэгдлийн зардлыг 93.3 мянган төгрөгөөр илүү тооцоолж тайлагнасан байна.	1	93.3	-	-	1	93.3	1	93.3	-	-	-	-
	Дүн	3	383,674.5	-	-	3	383,674.5	3	383,674.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал тны тоо
1	Мөнгөн гүйлгээний зардлын нийт 45,771,472.2 мянган төгрөгийн гүйлгээг цахим төлбөрийн баримтын системтэй тулган шалгахад 41,012.0 мянган төгрөгийн зардлын гүйлгээнд и-баримт бүртгэгдээгүй байна.	1	41,012.0	-	-	-	-	1	41,012.0	-	-	-	-
2	Бусад эргэлтийн хөрөнгө данснаас 591,319.6 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох дээд шатны байгууллагын тушаал шийдвэргүйгээр бүртгэлээс хасаж тайлагнасан байна.	1	591,319.6	-	-	1	591,319.6	-	-	-	-	-	-
	Дүн	2	632,331.6			1	591,319.6	1	41,012.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль, тогтоомж зөрчсөн асуудал									
1	Энигма констракшн ХХК-тай Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хороо дахь Гал түймэр унтраах, аврах 29 дүгээр ангийн барилга угсралтын 7,934,410.3 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэх FSBKH дугаартай гэрээг 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр байгуулж, 15 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр тохиролцсон. Гэрээт ажлын хугацааг 2 удаа сунгаж 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэрээний хугацаа дууссан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 60.2 хувьтай байна.	1	-	-	-	1	-	-	-
2	Модернхас ХХК болон Энерготех сервис ХХК-ийн түншлэлтэйгээр Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 20 дугаар хороо, Цэргийн хотхон орон сууцны хороолол орчмын Б хэсэгчилсэн талбай дахь гадна дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээний барилга угсралтын 4,734,941.5 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэх гэрээг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр байгуулж, 12 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр тохиролцсон байна. Гэрээт ажлын хугацааг 1 удаа сунгаж 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэрээний хугацаа дууссан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 68.1 хувьтай байна.	1	-	-	-	1	-	-	-
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
3	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр байршуулах 16,432,494.45 мянган төгрөгийн 28 мэдээллийг байршуулаагүй байна.	1	16,432,494.5	-	-	-	-	1	16,432,494.5
Дүн		3	16,432,494.5	-	-	2	-	1	16,432,494.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1220/АД150185

Улаанбаатар хот

САГ - 2026/56/КА - СТА - ТХМ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бусад эргэлтийн хөрөнгийн данснаас 3 нэр төрлийн 88 ширхэг 591,319,577.0 /таван зуун ерэн нэгэн сая гурван зуун арван есөн мянга таван зуун далан долоон/ төгрөгийн хөрөнгийг холбогдох дээд шатны газрын тушаал шийдвэргүйгээр бүртгэлээс хасаж тайлагнасан байна.




Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 5.1-т "Хуулийн этгээдийн дарга /захирал/ нь илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг бусад байгууллага руу балансаас балансад шилжүүлэн өгөх болон бусад байгууллагын эзэмшилд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа энэ журмын 1.3-д заасан бичиг баримтыг бүрдүүлэн Өмчийн харилцааны газарт ирүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулан өаланс тайланд хөдлөл өөрчлөлт хийнэ", 5.2-т "Нийслэлийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн гарсан Нийслэлийн Засаг даргын захирамжаар, тээврийн хэрэгслийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар, бусад хөрөнгийг Өмчийн харилцааны газрын үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын шийдвэрийг үндэслэн гарсан Өмчийн харилцааны газрын даргын тушаалаар балансаас балансад шилжүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тусламжаар бэлтгэсэн хөрөнгийг тушаал шилжүүлсэн асуудлыг шийдвэрлэж байгаа, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-н өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Улаанбаатар хотын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч /Б.Баатарзориг/, санхүүгийн ажилтан /Д.Дарьсүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР		В.ЭРДЭНЭЦОГТ
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ		Ч.ЭНХТУЯА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1218/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/56/КА-СТА-ТХV

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Энигма констракшн ХХК-тай Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хороонд Гал түймэр унтраах, аврах 29 дүгээр ангийн барилга угсралтын 7,934,410,273.00 /долоон тэрбум есөн зуун гучин дөрвөн сая дөрвөн зуун арван мянга хоёр зуун далан гурван/ төгрөгийн ажлыг 15 сарын хугацаанд гүйцэтгүүлэхээр 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр FSBKH дугаартай гэрээг байгуулсан байна. Гэрээт ажлын хугацааг 2 удаа сунгасан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэрээний хугацаа дууссан боловч барилга угсралтын ажлын гүйцэтгэл 60.2 хувьтай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 7.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана", Энигма констрашн ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 03-ний өдрийн FSBKH-Нэмэлт өөрчлөлт-2 дугаар бүхий Гэрээний ерөнхий нөхцөл болон заалтууд дахь нэмэлт өөрчлөлтийн 23.1, 37.1-д ажил дуусгах хугацааг "2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор" гэж заасныг тус тус мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Байгуулсан FSBKH дугаартай гэрээ болон нэмэлт өөрчлөлтүүдийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийн дагуу гэрээний үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээний хугацааг мөрдөөгүй, төслийн зээлийн үр дүнг тооцоогүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Улаанбаатар хотын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч /Б.Баатарзориг/, санхүүгийн ажилтан /Д.Дарьсүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

В.ЭРДЭНЭЦОГТ

Ч.ЭНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1219/АД150185

Улаанбаатар хот

САГ - 2026/56/НА - СТА - ТХИ

Зөрчил таслан зогсоох-тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Модернхас ХХК болон Энерготех сервис ХХК-ийн түншлэлтэйгээр Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 20 дугаар хороо, Цэргийн хотхон орон сууцны хороолол орчмын Б хэсэгчилсэн талбай дахь гадна дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээний барилга угсралтын 4,734,941,752.95 /дөрвөн тэрбум долоон зуун гучин дөрвөн сая есөн зуун дөчин нэгэн мянга долоон зуун тавин хоёр төгрөг ерэн таван мөнгө/ төгрөгийн ажлыг 12 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр SHTSC-A дугаартай гэрээг байгуулсан. Гэрээт ажлын хугацааг 1 удаа сунгасан бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 30-ний өдөр гэрээний хугацаа дууссан боловч барилга угсралтын ажлын гүйцэтгэл 68.1 хувьтай байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 7.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана", Мондернхас ХХК, Энерготех сервис ХХК-иудын түншлэлтэй 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн SHTSC-A-Нэмэлт өөрчлөлт-1 дугаар бүхий Гэрээний ерөнхий нөхцөл болон заалтууд дахь нэмэлт өөрчлөлт 23.1, 37.1-д ажил дуусгах хугацааг 2025 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн дотор" гэсэн заалтыг тус тус мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгуулсан SHTSC-A дугаартай гэрээ болон нэмэлт өөрчлөлтүүдийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийн дагуу гэрээний үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээний хугацааг мөрдөөгүй, төслийн зээлийн үр дүнг тооцоогүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Улаанбаатар хотын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч /Б.Баатарзориг/, санхүүгийн ажилтан /Д.Дарьсүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР		В.ЭРДЭНЭЦОГТ
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ		Ч.ЭНХТУЯА